

**НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Өөрийн байр, Баянголын гудамж 1, 27 дугаар хороо,
Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот, 18082
Утас: (976) 7017 0109
Цахим хуудас: www.shd.mn

2024.05.16 № 03/1406
танай _____-ны № _____-г

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

СХД-ийн Худалдан авах ажиллагааны албанаас зарлагдсан Хорооны барилга (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг 39, 43 дугаар хороо) НХААГ/20240101180 дугаартай ажилд оролцогч байгууллагууд тодруулга хүссэн байна. Хүсэлтийн дагуу үнэлгээний хороо 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр хуралдаж тодруулгын хариуг хүргүүлж байна. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн:

1.ТШЗ 19.1-д заасан "Усан хангамж ариутгах татуурга инженер 2 болон түүнээс дээш жил ажилласан үндсэн ажилтан байна" гэж заасан. Тухайн компанид хэдэн сар ажиллаж байгаа нь хамааралгүй бөгөөд тухайн компанид үндсэн ажилтны даатгуулагчийн төрлөөр нийгмийн даатгалын шимтгэл төлдөг ажилтан 01001 кодтой байна. Ажилласан жилийн туршлага 2 жил байх шаардлагатай;

2.ТШЗ 19.1-д заасан сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилийн төсөвт өртгийн 30 хувиас багагүй буюу 506,580,000 (таван зуун зургаан сая таван зуун наян мянга) төгрөгөөс багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр дор хаяж нэг удаа ажилласан байх гэж заасан. Ижил төстэй барилга угсралтын ажилд захиалагчийн төрлийг заагаагүй ба хувь хүний хөрөнгө оруулалттай комисс ажилласан барилга угсралтын ажил байж болно гэж үнэлгээний хороо шийдвэрлэсэн.

Бусад шаардлагатай материалыг батлагдсан зураг, төсөв, тендерийн баримт бичгийн дагуу материалаа бүрдүүлэн ирүүлнэ үү.

Жич: Тус тодруулгатай холбоотойгоор асуух зүйл байвал доорх хаягаар тодруулж болно.

Сонгинохайрхан дүүрэг, 27 дугаар хороо, Баянголын 1 дүгээр гудамж, 3 давхарт, 302 тоот, Нутгийн захиргааны нэгдсэн байр, Худалдан авах ажиллагааны алба

Цахим шуудангийн хаяг: haaashd24@gmail.com, Утасны дугаар: 7000 0717